



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2021. 01. 07 № 03/44

танай _____-ны № _____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ

Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2020 оны жилийн эцсийн тайлан, мэдээг хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.


ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Т.НАНДИНЖАРГАЛ



d:\уухүя 2021 Яам а5.docx

08 0033

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны
2021 оны...01...сарын...03...өдрийн
...03/11...албан бичгийн хавсралт



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,
ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН
/2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

ХҮСНЭГТ №1

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт %
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Хугацаа болоогүй	
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	305	303	-	-	2	99.33%
2	Ашигт малтмал, газрын тосны газар	448	448	-	-	-	100%
НИЙТ		753	751			2	99.67%

2020 ОНД ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ
ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ /хэлбэрээр/

ХҮСНЭГТ №2

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс:				
			Бичгээр	Цахимаар	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	305	305	-	-	-	-
2	Ашигт малтмал, газрын тосны газар	448	448	-	-	-	-
НИЙТ		753	753	-	-	-	-

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА

ХҮСНЭГТ №3

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал тоо /нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь
1 2	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Ашигт малтмал, газрын тосны газар	<p>Нийт 753 өргөдлөөс:</p> <ul style="list-style-type: none"> • Хүсэлт – 464 буюу 61.6% • Гомдол - 280 буюу 37.2% • Санал – 9 буюу 1.2% <p>Агуулгаар нь ангилвал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүний нөөцийн асуудлаар – 281 буюу 37.3% 2. Тусламж, дэмжлэг хүссэн – 54 буюу 7.1% 3. Чөлөө хүссэн – 33 буюу 4.3% 4. Орон сууцны дэмжлэг хүссэн – 11 буюу 1.4% 5. Зөвлөх болон мэргэшсэн зэрэг – 4 буюу 0.5% 6. Геологи, уул уурхайтай холбоотой асуудлаар – 20 буюу 2.6% 7. Түлш, газрын тосны асуудлаар – 14 буюу 1.8% 8. Дэд бүтцийн асуудлаар – 1 буюу 0.1% 9. Байгаль орчны асуудлаар – 2 буюу 0.2% 10. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар – 211 буюу 28.0% 11. Сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар – 24 буюу 3.1% 12. 1072 хувьцаатай холбоотой асуудлаар – 5 буюу 0.6% 13. Бусад – 93 буюу 12.7% Үүнээс: <ul style="list-style-type: none"> • Лавлагаа мэдээлэл – 73 буюу 9.6% • Салбарын шагналын тэмдэг дахин олгох - 7 буюу 0.9% • Сургалттай холбоотой асуудлаар - 4 буюу 0.5% • Нийгмийн даатгалтай холбоотой асуудлаар - 4 буюу 0.5% • Ёс зүй 5 буюу 0.6%

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,
ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол болон холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэн авч, судалж шийдвэрлэн хуулийн хугацаанд хариу өгч ажиллав.

Тус яаманд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын агуулга, шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулан хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд тогтмол хяналт тавин, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээ, тайланг 14 хоног тутам Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулан ажиллаж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 753 өргөдөл, гомдол албан бичгээр ирсэн байна. Эдгээрээс хариуг шийдвэрлэж албан бичгээр өгсөн 751, үүнээс хугацаа болоогүй 2 өргөдөл ба шийдвэрлэлт 99,67%-тай байна.

Иргэдээс хандаж ирсэн 753 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс хүний нөөцийн асуудлаар 281 буюу 37.3%, тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар 211 буюу 28.0%, тусламж, дэмжлэг хүссэн 54 буюу 7.1%, лавлагаа 73 буюу 9.6%, геологи, сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар 24 буюу 3.1%, уул уурхайтай холбоотой асуудлаар 20 буюу 2.6%, түлш, газрын тосны асуудлаар 14 буюу 1.8%, бусад асуудлаар 93 буюу 12.7% байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын тэмдэглэлийг тогтмол хөтөлж хэвшсэн үзүүлэлттэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн удирдлагын шуурхай хуралдаанаар тус яаманд болон харьяа байгууллага Ашигт малтмал, газрын тосны газарт иргэдээс хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг танилцуулж сар бүрийн сүүлийн 7 хоногт тайлан, мэдээг Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлж ажиллах талаар чиглэл өгч, чиглэлийн дагуу хяналт тавин ажиллаж байна.

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

1. Монгол Улсын Засгийн газрын 2019.09.04-ний өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэлийн дагуу Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд Төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэхэд анхаарч 7 хоног бүрийн Байгууллагын удирдлагын зөвлөлийн шуурхай хуралдаанаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал танилцуулагдан холбогдох нэгжийн дарга, хариуцсан мэргэжилтэн нар өргөдөл, хүсэлтэд дурдсан санал, гомдлыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.
2. Өргөдөл нь тус яамны эрхлэх асуудлын хүрээнд шууд шийдвэрлэх боломжгүй, холбогдох газрын шийдвэр, хариуг хүлээх зэргээс шалтгаалж байгаа тохиолдолд шийдвэрлэлтийн явцыг тэмдэглэх эсхүл иргэн, аж ахуйн нэгжид өргөдлийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг утсаар болон цахимаар мэдээллэж байна.
3. Коронавируст халдвар(Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор гэрээсээ цахимаар ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга үүрэг болгосон. Өгсөн үүргийн дагуу Төрийн захиргааны удирдлагын газрын дарга иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд цаг алдалгүй, шуурхай шийдвэрлэн ажиллах талаар хяналт тавин ажилласан бөгөөд өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 99,67%-тай байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ